

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
377 дугаар тогтоолоор батлагдсан
“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК
Хаяг, утас	Дундговь аймаг, Сайнцагаан сумын 7 дугаар баг, Буяаннэмэхийн өргөн чөлөө, компанийн өөрийн байр
Хурал хуралдах өдөр, цаг	2025.04.30-ны 18.00 цаг
Хурал хуралдах газар, байршил	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Самбуугийн гудамж, “Орон зай” төв 701 тоот
Хурлын төрөл	Ээлжит Ээлжит бус
Хурал зарлагч	ТУЗ ТУЗ-ийн 2 ба түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2025 оны 03 сарын 21-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2025-03-25, 2025-04-09
Бүртгэлийн өдөр	2025 оны 04 сарын 14-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо	2025 оны 03 сарын 30-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2025 оны 03 сарын 24-ны өдөр
Хурлын даргын нэр	М.Отгонбаатар
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Н.Оюунгэрэл, Д. Мөнхтөмөр, Ю.Будсүрэн
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт бичгийн хуудасны тоо	 ширхэг хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА



/Э.МӨНХЗУЛ/

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025.03.21

№: 01

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААНЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 32.1 дэх заалтууд 2025 оны 02-р сарын 15-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн гишүүдийн хуралдааны тэмдэглэл, санал хураалтын дүн, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12-р сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Өлзий Дундговь” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 18,00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Самбуугийн гудамжны “Орон зай” төвийн 701 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр батлуулсугай. Үүнд:
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-аас гаргасан дүгнэлт
 - Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ-аас гаргасан шийдвэрийг танилцуулах
 - ТУЗ-ын гишүүдийг сонгох
 - Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах
 - Их хэмжээний хэлцэл батлах
 - Компанийн оноосон нэр өөрчлөх
 - Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх
 - Компанийн дүрэм өөрчлөх
 - Бусад асуудал
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөрийг 2025 оны 04 сарын 14-ны өдөрөөр тогтоосугай
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг 2025 оны 03 сарын 25, 04 сарын 09-ны өдрүүдэд өдөр тутмын сонин болон компанийн веб хуудсуудаар дамжуулан мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компаниудад хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд хүргэх ажлыг


зохион байгуулахыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комиссын дарга /Э.Мөнхзул/-д даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлуудаар санлын хуудсаар санал авах "Саналын хуудас"-ны агуулгыг хавсралт 2-д заасанаар баталсугай.
7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлуудаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 10,00 цагаар тасалбар болгон хаасугай.
8. Хурал удирдах, хурал зохион байгуулах, тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай
 - М.Отгонбаатар /Хурлын дарга/
 - Э.Мөнхзул /хурал зохион байгуулах комиссын дарга/
 - Н.Оюунгэрэл / тооллогын комиссын дарга/
 - Д.Мөнхтөмөр /тооллогын комиссын гишүүн/
 - Ю.Будсүрэн /тооллогын комиссын гишүүн/
9. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс-т даалгасугай.
10. "Өлзий Дундговь" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шийдвэр гарсанаас хойш 3 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн бирж-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Э.Мөнхзул/*д даалгасугай.

ТУЗ-ын Дарга



/Т.ОЮУНБААТАР/



“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ

“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна:

Хурал болох газар:

“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 18.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2-р хороо Самбуугийн гудамж, “Орон зай” төв 701 тоотод хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр


2025 оны 04 сарын 14-ны өдөр

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-аас гаргасан дүгнэлт
- Ноогдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ-аас гаргасан шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ын гишүүдийг сонгох
- Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах
- Их хэмжээний хэлцэл батлах
- Компанийн оноосон нэр өөрчлөх
- Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх
- Компанийн дүрэм өөрчлөх
- Бусад асуудал

Хурал зохион байгуулах комиссын Э.Мөнхзул болон гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас: 99772722, 98106064

Майл хаяг: monsec99@yahoo.com



**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 18.00 цагт цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо, Самбуугийн гудамж орон зай төв 701 тоотод болно.

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/ овогтой
Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай
тайлбар:

Регистрийн дугаар.....

Гэрийн хаяг

Эзэмшиж буй хувьцааны тоо.....

Кумулятив аргаар өгөх саналын тоо.....

Бүртгэсэн:/Үнэт цаасны компанийн нэр /

Брокерын овогнэр.....

№	Хурлаас гарах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1.	Компанийн 2024 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;			
2	Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах			

3	Их хэмжээний хэлцэл батлах				
4	Компанийн оноосон нэр өөрчлөх				
5	Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх				
6	Компанийн дүрэм өөрчлөх				
7.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох				
	1. Д.Зоригтбаатар	Кумулятив аргаар сонгох ТУЗ-ийн ердийн гишүүд			
	2.				
	3.				
	4.				
	5.				
	6				
	1. Д.Олдох	Кумулятив аргаар сонгох ТУЗ-ийн хараат бус гишүүд			
	2.				
	3.				
	4.				

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... /

Санал авахыг хуудсыг хүчингүйд тооцсан бол шалтгаан.....

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга /

Гишүүн..... /

Шалгаж хүлээн авсан БДК-ийн ажилтан..... /

"ӨЛЗИЙ ДУНДГОВЬ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн АНХААРАЛД

"ӨЛЗИЙ ДУНДГОВЬ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 18.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2-р хороо Самбуугийн гудамж, "Орон зай" төв 701 тоотод хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр

2025 оны 04 сарын 11-ны өдөр


Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ:


- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-аас гаргасан дүгнэлт
- Ноогдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ-аас гаргасан шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ын гишүүдийг сонгох
- Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах
- Их хэмжээний хэлцэл батлах
- Компанийн оноосон нэр өөрчлөх
- Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх
- Компанийн дүрэм өөрчлөх
- Бусад асуудал

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК дээр ажлын өдрүүдэд /Даваа-Баасан/ 9:00 цагаас 16:00 хүртэл авах боломжтой

Хурал зохион байгуулах комиссын Э.Мөнхзул болон гишүүдтэй холбоо барих, мэдээлэл авах утас: 99772722, 98106064

Майл хаяг: monsec99@yahoo.com





2025 оны 03 дугаар сарын 21 -ны өдрийн 01 тоот тогтоолын Хавсралт №03

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛЫН ДЭГ**

“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 18.00 цагт цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2 дугаар хороо, Самбуугийн гудамж орон зай төв 701 тоотод болно.

Д/д	Хуралдааны дараалал	Зарцуулах хугацаа	Хариуцах эзэн
1	Бүртгэлийн үйл ажиллагаа	10 минут	Тооллогын комисс
2	Хурлыг нээж дэгийг танилцуулж батлах	5 минут	Хурлын дарга
3	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлаар баталгаажсан санхүүгийн тайлан танилцуулах	5 минут	Хурлын дарга
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ын болон Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэж батлах	5 минут	Аудитын хорооны дарга
5	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын “Ноогдол ашиг хувиарлах тухай” 2025 оны 02 сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолыг танилцуулах	5 минут	Хурлын дарга
6	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг дуусгавар болгох тухай	10 минут	Хурлын дарга
7	Их хэмжээний хэлцэл батлах, компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах тухай	5 минут	Хурлын дарга

8	Компанийн оноосон нэр, дүрмийг өөрчлөх, Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай	20 минут	Хурлын дарга
9	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт хариулт	20 минут	Хурлын дарга
10	Саналын хуудсаар санал авах	10 минут	Тооллогын комисс
11	Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	15 минут	Тооллогын комисс
12	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж тогтоолын төслийг батлах	5 минут	Хурлын дарга

Хурал үргэлжлэх хугацаа 2 цаг 30 минут

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025.04.30

№:

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ
СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дах заалт, 77-р зүйлийн 77.4 дугаар заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр нэр дэвшүүлэн сонгосон гаргасан дараах гишүүдийг ТУЗ-ын гишүүнээр томилсугай.
 - ТУЗ-ын ердийн гишүүнээр Д.Зоригтбаатар
 - ТУЗ-ын хараат бус гишүүнээр Д.Олдох
2. Компанийн ТУЗ-ын гишүүнээр сонгогдож буй Д.Зоригтбаатар, Д.Олдох нарт компанийн хууль болон, компанийн дүрмийн дагуу ТУЗ-ын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ОТГОНБААТАР

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025.04.30

№:

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон
аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дах заалт, 96-р зүйлийн 96.5 дугаар
заалт, “Өлзий Дундговь” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын
комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитийн хорооны дүгнэлийг Хавсралт 01-ээр
баталсугай

ХУРЛЫН ДАРГА

М.ОТГОНБААТАР

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025.04.30

№:

Улаанбаатар хот

Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах ,
их хэмжээний хэлцэл хийх эрхийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 88-р зүйлийн 88.1 дах заалт, “Өлзий Дундговь” ХК-ны
хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ**
НЬ:

1. Компанийн өмчлөлд байгаа дэлгүүр, худалдааны зориулалттай хуучин үл хөдлөх хөрөнгийг компанийг үүсгэн байгуулагчид, жижиг хувьцаа эзэмшигчдэд компанийн блансад тусгасан үнээр нь худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй
2. Компанийн өмчлөлд байсан эд хөрөнгийг худалдан борлуулсантай холбогдуулан тайлан блансаас хасалт хийхийг гүйцэтгэх захирал Д.Уламбаяр болон санхүүгийн албанд даалгасугай

ХУРЛЫН ДАРГА

М.ОТГОНБААТАР

**“ӨЛЗИЙ ДУНДГОВЬ” ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025.04.30

№:

Улаанбаатар хот

Компанийн оноосон нэр, дүрмийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1 дэх заалт, 62-р зүйлийн 62.1 дах заалт, “Өлзий Дундговь” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн оноосон нэрийг “Цойлогсод Эй Ай” ХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт-1 ээр баталсугай
3. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Д.Уламбаярт даалгасугай
4. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай

ХУРЛЫН ДАРГА

М.ОТГОНБААТАР